



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/12

Улаанбаатар хот

Биеийн тамир, спорт хамтлаг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2, 13.1.3, 13.1.4, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Албан хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх, амьдралын зохистой хэвшлийг төлөвшүүлэх зорилгоор хамт олны дунд биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн арга хэмжээг төлөвлөн зохион байгуулах, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дунд зохион байгуулагдах спортын арга хэмжээнд хамт олны оролцоо, идэвхийг нэмэгдүүлэн ажиллах үүрэг бүхий Биеийн тамир, спортын хамтлагийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Хамт олны хэмжээнд зохион байгуулах биеийн тамир спортын арга хэмжээний төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, ажлын үр дүнг хагас жил тутам тайлагнаж ажиллахыг Биеийн тамир спортын хамтлаг (М.Цогтбилэг)-т үүрэг болгосугай.

3. Биеийн тамир, спорт хамтлагийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (О.Оджаргал)-д даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан "Биеийн тамир, спорт хамтлаг шинэчлэн байгуулах тухай" Газрын даргын 2021 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/39 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



О.ТӨМӨРДУЛАМ

Газрын даргын 2022 оны 03 дугаар
сарын 01-ны өдрийн 1/12 дугаар
тушаалын хавсралт



БИЕИЙН ТАМИР, СПОРТ ХАМТЛАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч:	М.Цогтбилэг	Хот нийтийн аж ахуйн стандартын хэлтсийн Ахлах мэргэжилтэн
Гишүүд:	С.Болдоо	Захиргаа, санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн
	М.Амарзаяа	Хотын хөгжлийн стандартын хэлтсийн мэргэжилтэн
	Б.Хулан	Байгаль орчны стандартын хэлтсийн мэргэжилтэн
	М.Чингүн	Стандартын хэрэгжилт, хяналтын хэлтсийн мэргэжилтэн
Нарийн бичиг:	Б.Батболд	Худалдаа үйлчилгээний стандартын хэлтсийн мэргэжилтэн